Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар
сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
"Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт
"Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон
тухай бүр мэдээлэх мэдээллийн агуулга, хэлбэр"-ийн
Жилийн үйл ажиллагааны тайлагнал маягт 1

**Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/**

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл илгээж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | | |
|---|---|---|
| | *Тайлагнах хугацаа* | 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/ |
| | *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Ард Даатгал ХК, 9010002002, РД:2062089, MSE:AIC, 77200088 |
| | *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын Хөрөнгийн Бирж |
| | *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Ердийн даатгал |
| | *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | Грант Торнтон Аудит ХХК |
| | *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 25,000,000 |
| | *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Баярбат,<br>Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах |
| 1 | **Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/** | |
| | *Санхүүгийн байдлын тайлан* | Хавсралт 1 |
| | *Орлогын тайлан* | Хавсралт 2 |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | Хавсралт 3 |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | Хавсралт 4 |
| 1.1. | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | Аудитын компаниас Эерэг дүгнэлт өгсөн. |
| 1.2. | *Аудитын тодорхойлох захидал* | Хавсралт 5 |
| 2 | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| 2.1. | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд/* | Хавсралт 6 |
| 2.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт* | Хавсралт 6 |
| 2.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | Хавсралт 6 |
| 2.4. | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Бодлого байхгүй. Эксел тайлан хөтөлдөг. |
| 2.5. | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл* | Ямар нэг зээл аваагүй бөгөөд баталгаа гаргаж өгөөгүй болно. |
| 3 | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн гүйлгээ хийгдээгүй. |
| 4 | *Цалин урамшууллын мэдээлэл* | Хавсралт 6 |
| 5 | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | Хавсралт 6 |
| 6 | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* | Хавсралт 6 |
| 7 | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* | Хавсралт 6 |
| 8 | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* | Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд хувьцаа санал болгож гаргаагүй болно. |
| 9 | *Ногоон ашгийн мэдээлэл* | Хавсралт 6 |
| 10 | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* | Хавсралт 6 |

**Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:**

| | |
|---|---|
| Овог, нэр: Г. Цогбадрах<br>Албан тушаал: "Ард Даатгал" ХК-ийн Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ……………………………………<br><br>*(Тамга/тэмдэг)* | Овог, нэр: Б. Осоргарав<br>Албан тушаал: "Грант Торнтон Аудит" ХХК аудитын компанийн Удирдах Партнер<br><br>Гарын үсэг: ……………………………………..<br><br>*(Тамга/тэмдэг)* |

**Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:**

Овог, нэр: Г. Баярбат

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ……………………………………

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 1

## ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Даатгагчийн нэр: Ард Даатгал ХК — 2021 оны 12 сарын 31-ны өдөр

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| Бэлэн мөнгө | 368,463.95 | 302,130.00 |
| Харилцах | 1,029,219,367.89 | 971,193,838.33 |
| Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | 147,005,904.57 | 11,603,658.95 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн** | **1,176,593,736.41** | **983,099,627.28** |
| Даатгалын хураамжийн авлага /цэвэр дүнгээр/ | 1,607,131,742.88 | 2,676,136,882.37 |
| Буруутай этгээдээс авах авлага /цэвэр дүнгээр/ | 506,743,029.16 | 860,587,663.15 |
| Давхар даатгалаас авах авлага /цэвэр дүнгээр/ | 30,681,863.02 | 30,681,863.02 |
| **Даатгалын авлагын дүн** | **2,144,556,635.06** | **3,567,406,408.54** |
| Бусад авлага /цэвэр дүнгээр/ | 693,824,405.15 | 1,712,439,989.20 |
| **Бусад санхүүгийн хөрөнгийн дүн** | **693,824,405.15** | **1,712,439,989.20** |
| Бараа материал | 16,992,459.97 | 25,095,020.59 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 904,917,168.49 | 921,620,190.85 |
| **Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн** | **921,909,628.46** | **946,715,211.44** |
| Хадгаламж, хадгаламжийн сертификат | 10,283,149,787.53 | 10,398,429,579.93 |
| Үнэт цаас /цэвэр/ | 7,726,241,975.56 | 13,211,468,269.07 |
| **Хөрөнгө оруулалтын дүн** | **18,009,391,763.09** | **23,609,897,849.00** |
| ДД-ын хойшлогдсон хураамж | 2,033,476,240.27 | 849,845,480.48 |
| Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг | 446,928,283.09 | 49,235,364.55 |
| Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал | 920,891,600.96 | 1,025,166,090.04 |
| **Даатгалын хөрөнгийн дүн** | **3,401,296,124.32** | **1,924,246,935.07** |
| **Үндсэн хөрөнгө /Цэвэр/** | **2,428,893,263.42** | **2,082,238,100.32** |
| **Биет бус хөрөнгө /Цэвэр/** | | |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **28,776,465,555.91** | **34,826,044,120.84** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| Даатгалын хураамжийн буцаалтын өглөг | 2,235,880.70 | 4,709,646.70 |
| Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг | 75,179,763.93 | 85,778,651.56 |
| ДД өгөх өглөг | 3,065,521,515.14 | 2,174,867,852.45 |
| **Даатгалын өглөгийн дүн** | **3,142,937,159.77** | **2,265,356,150.71** |
| Санхүүгийн түрээсийн өр төлбөр | | |
| Ногдол ашгийн өглөг | | |
| Бусад өр төлбөр | 1,151,113,281.67 | 941,160,068.03 |
| **Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн** | **1,151,113,281.67** | **941,160,068.03** |
| Цалингийн өглөг | | 165,812.84 |
| НДШ-ийн өглөг | | |
| ААНОАТатварын өглөг | 32,899,385.94 | 155,500,677.30 |
| Хойшлогдсон татварын өглөг | 106,716,160.85 | 821,579,610.57 |
| Урьдчилж орсон орлого | 193,188,182.40 | 290,407,132.76 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 39,601,767.53 | 247,678,567.13 |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн** | **372,405,496.73** | **1,515,331,800.60** |

| | | |
|---|---|---|
| **Орлогод тооцоогүй хураамжийн нөөц** | **7,690,099,868.63** | **8,306,999,556.48** |
| Учирсан боловч мэдэгдээгүй ХНС | 805,014,604.89 | 1,076,864,065.77 |
| Мэдсэн боловч төлөөгүй ХНС | 918,529,241.95 | 642,373,205.41 |
| Учирч болзошгүй ХНС | 756,130,221.51 | 1,040,859,530.51 |
| Тусгай нөөц сан | 641,252,775.83 | 641,252,775.83 |
| **Нөөц сангийн дүн** | **3,120,926,844.19** | **3,401,349,577.52** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **15,477,482,650.99** | **16,430,197,153.34** |
| **Эзэмшигчдийн өмч** | **5,000,000,000.00** | **5,000,000,000.00** |
| **Нэмж төлөгдсөн капитал** | **3,280,854,472.00** | **3,280,854,472.00** |
| **Хуримтлагдсан ашиг, алдагдал** | 5,018,128,432.92 | 10,114,992,495.50 |
| **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **13,298,982,904.92** | **18,395,846,967.50** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **28,776,465,555.91** | **34,826,044,120.84** |

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 2

## ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр: Ард Даатгал ХК 2021 оны 12 сарын 31-ны өдөр

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **Даатгалын хураамжийн нийт орлого** | **15,713,524,660.42** | **16,462,353,000.40** |
| Даатгалын хураамжийн буцаалт | 201,559,731.38 | 570,234,497.94 |
| Давхар даатгалын хураамжийн зардал | 4,386,090,288.50 | 2,398,879,737.27 |
| **Даатгалын хураамжийн цэвэр орлого** | **11,125,874,640.54** | **13,493,238,765.19** |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт | 2,814,861,637.90 | 616,899,687.85 |
| Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт | 1,382,690,394.34 | (1,183,630,759.79) |
| **Орлогод тооцсон хураамж** | **9,693,703,396.98** | **11,692,708,317.55** |
| Нийт нөхөн төлбөрийн зардал | 4,718,693,766.35 | 4,966,724,479.00 |
| Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр | 547,322,701.35 | 336,403,423.89 |
| Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр | 503,943,356.00 | 481,602,749.00 |
| **Нөхөн төлбөрийн цэвэр зардал** | **3,667,427,709.00** | **4,148,718,306.11** |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт | 306,019,120.66 | (4,306,575.67) |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт | (317,165,898.68) | 397,692,918.55 |
| Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт | (189,992,659.91) | 284,729,309.00 |
| **Зардалд тооцсон нөхөн төлбөр** | **3,466,288,271.06** | **4,826,833,957.99** |
| Даатгалын гэрээний зардал | 1,810,430,097.82 | 2,153,742,850.60 |
| Давхар даатгалын шимтгэлийн орлого | 131,275,735.17 | 178,126,943.58 |
| Хөрөнгө оруулалтын олз, гарз | 2,515,906,182.01 | 9,294,759,267.33 |
| **Даатгалын үйл ажиллагааны ашиг(алдагдал)** | **7,064,166,945.27** | **14,185,017,719.87** |
| Түрээсийн орлого | | |
| Хүү, Эрхийн шимтгэлийн орлого | 45,009,239.53 | 370,014.92 |
| Бусад орлого | 197,753,911.59 | 153,226,780.20 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,809,879,333.41 | 2,079,966,882.37 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 2,451,983,174.25 | 3,532,465,231.08 |
| Санхүүгийн зардал | 22,499,510.25 | 41,589,941.94 |
| Бусад зардал | 618,014,124.45 | 465,275,666.21 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | (30,852,557.22) | 4,334,105.14 |
| Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 837,021.25 | 98,257,137.30 |
| **Бусад ашиг ( алдагдал)** | **(4,689,628,527.21)** | **(5,863,109,684.04)** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)** | **2,374,538,418.06** | **8,321,908,035.83** |
| Орлогын албан татварын зардал | 226,737,025.80 | 1,145,927,634.03 |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **2,147,801,392.26** | **7,175,980,401.80** |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 85.91 | 287.04 |

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 3

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Даатгагчийн нэр: Ард Даатгал ХК

2021 оны 12 сарын 31-ны өдөр
*(төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **5,000,000,000.00** | | **3,280,854,472.00** | | **3,524,155,010.05** | **11,805,009,482.05** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | 196,172,030.60 | **196,172,030.60** |
| Залруулсан үлдэгдэл | 5,000,000,000.00 | | 3,280,854,472.00 | | 3,720,327,040.66 | **12,001,181,512.66** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 2,147,801,392.27 | **2,147,801,392.27** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | (850,000,000.00) | **(850,000,000.00)** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | |
| **2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **5,000,000,000.00** | | **3,280,854,472.00** | | **5,018,128,432.92** | **13,298,982,904.92** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | 5,000,000,000.00 | | 3,280,854,472.00 | | 5,018,128,432.92 | **13,298,982,904.92** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 7,175,980,401.80 | **7,175,980,401.80** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | (1,079,116,339.22) | **(1,079,116,339.22)** |
| Зарласан ногдол ашиг | | | | | (1,000,000,000.00) | **(1,000,000,000.00)** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | |
| **2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **5,000,000,000.00** | | **3,280,854,472.00** | | **10,114,992,495.50** | **18,395,846,967.50** |

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 4

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр: Ард Даатгал ХК

2021 оны 12 сарын 31-ны өдөр
*(төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **19,591,133,787.44** | **18,270,785,155.72** |
| Даатгалын хураамжийн орлого | 14,109,946,944.69 | 14,778,490,285.44 |
| Давхар даатгалын нөхөн төлбөр | 98,427,924.15 | |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| Бусад мөнгөн орлого | 5,382,758,918.60 | 3,492,294,870.28 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **18,431,913,256.49** | **17,754,504,051.11** |
| Ажиллагчдад төлсөн | 1,356,397,476.12 | 1,353,791,100.78 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 188,991,127.63 | 413,519,617.10 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 142,150,010.87 | 137,044,087.06 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 6,489,379.00 | 7,484,200.00 |
| Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж | 1,442,865,802.34 | 942,490,401.86 |
| Нөхөн төлбөрт төлсөн | 4,550,449,453.00 | 4,306,538,402.30 |
| Үүнээс: Сайн дурын даатгалын | 3,370,206,832.21 | 3,153,640,155.21 |
| Албан журмын даатгалын | 1,180,242,620.79 | 1,152,898,247.09 |
| Даатгалын төлөөлөгчийн шимтгэл | 1,236,142,938.78 | 1,494,057,896.99 |
| Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр | 761,647,243.35 | 763,959,442.68 |
| Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр | 13,422,200.00 | |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 61,534,800.00 | 44,160,341.00 |
| Хүүний төлбөрт төлсөн | | 2,051,774.49 |
| Татварын байгууллагад төлсөн | 710,297,053.65 | 764,168,927.94 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 18,875,563.89 | 27,416,796.40 |
| Бусад мөнгөн зарлага | 7,942,650,207.86 | 7,497,821,062.51 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **1,159,220,530.95** | **516,281,104.61** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **8,086,298,219.30** | **8,139,680,224.93** |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 7,700,000.00 | |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 6,808,377,698.44 | 6,282,767,968.79 |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| Хүлээн авсан хүүний орлого | 1,236,348,662.23 | 1,799,186,652.06 |
| Хүлээн авсан ногдол ашиг | 33,871,858.63 | 57,725,604.08 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **8,339,500,844.75** | **7,934,081,078.67** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 3,035,363.00 | 239,525,618.41 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 20,700,000.00 | |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 8,315,765,481.75 | 7,694,555,460.26 |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |

| | | |
|---|---|---|
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(253,202,625.45)** | **205,599,146.26** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | | |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| Төрөл бүрийн хандив | | |
| Бусад | | |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **151,489,994.63** | **915,374,360.00** |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| Төлсөн ногдол ашиг | 151,489,994.63 | 915,374,360.00 |
| Бусад | | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(151,489,994.63)** | **(915,374,360.00)** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **754,527,910.87** | **(193,494,109.13)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **422,065,825.54** | **1,176,593,736.41** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,176,593,736.41** | **983,099,627.28** |

Grant Thornton

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар 14230, Монгол улс
T + 976 70 110748
+ 976 70 110799

Dalai Tower, 9 Fl, UNESCO street, Sukhbaatar District-1, Ulaanbaatar 14230, Mongolia
T + 976 70 110748
+ 976 70 [illegible]

# Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

**"Ард Даатгал" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:**

*Дүгнэлт*

Бид "Ард Даатгал" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь аудитын тайлангийн тодруулгад тайлбарласны дагуу бүхий л материаллаг зүйлсийн хүрээнд аудит хийгдсэн тайлантай нийцэж байна

*Хураангуй санхүүгийн тайлан*

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Сангийн сайдын 2020 оны 132 тоот тушаалаар батлагдсан "Даатгалын компаниудад мөрдөгдөх Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга"-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Ард Даатгал" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2022 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

*Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт*

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд зэрэг дүгнэлт өгсөн.

*Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

*Аудиторын үүрэг хариуцлага*

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

**Б.ОСОРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**
Монгол улс, Улаанбаатар хот
2022 оны 3 дугаар сарын 29

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 6

**ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ**

Монгол улсад даатгалын салбар үүсч хөгжөөд 88 жил болж байгаа ба Ард Даатгал компани нь байгуулагдаад өдгөө 28 дах жилдээ үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд даатгалын зах зээлд ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, дотоодын давхар даатгалын 1, даатгалын зуучлалын 57, даатгалын хохирол үнэлэгч 25 компани, даатгалын төлөөлөгч 2.403 иргэн тус тус тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгө тайлант хугацаанд 425.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.4 тэрбум төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого, түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм.

*График. Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/*




Эх үүсвэр: Санхүүгийн Зохицуулах Хороо

Ердийн даатгалын компаниуд 2021 онд 241.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.5 тэрбум төгрөгөөр буюу 20.8 хувиар өссөн байна. Нийт хураамжийн сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 14.7 хувьтай байна. Нийт хураамжаас 6.1 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийгдэж, 84.4 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулснаар даатгалын цэвэр хураамжийн орлого 151.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Тайлант хугацаанд нийт 67 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 тэрбум төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн ба 145 их наяд төгрөгийн даатгалын үнэлгээ бүхий эрсдэлийг хүлээн авч үүнээс тодорхой хувийг нь давхар даатгалын компанид шилжүүлжээ. Компаниуд хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах хандлага жил ирэх тусам нэмэгдэж, 84 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг давхар даатгалд шилжүүлсэн байна. Мөн нийтдээ давхар даатгагчаас 4.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг төлүүлсэн байна.

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 6

**ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Ард Даатгал ХК нь 2021 онд үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулж, Улаанбаатар хот болон орон нутгийн 24 салбар нэгж, төлөөлөгчийн газар, системийн нөлөө бүхий 5 арилжааны банк, олон улсын болон дотоодын 70 гаруй брокер, мэргэжлийн оролцогч зуучлагч, олон тооны банк бус санхүүгийн байгууллага, 100 орчим даатгалын төлөөлөгчдөөрөө дамжуулан улс орон даяар даатгалын үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Ард Даатгал компани нь өнгөрсөн хугацаанд Монгол улсын онцог булан бүрт хүрч ажиллаж чадсан бөгөөд 2021 оны байдлаар нийтдээ 200 гаруй мянган даатгуулагчийг даатгалд хамруулаад байгаа төдийгүй үүнээс хоёр мянга гаруй байгууллагатай 15 мянга гаруй гэрээ байгуулсан.

Бид сайн дурын болон албан журмын төрөл бүхий Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон сайн дурын даатгалын гэнэтийн осол, амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлага, санхүүгийн даатгал, сууц өмчлөгчдийн хариуцлагын даатгал, газар тариалангийн даатгалын хэлбэрээр 50 гаруй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байгаа төдийгүй “Жолоочийн даатгалын тухай” хуулийн дагуу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байна.

Ард Даатгал компанийн хувьд Монгол Улсад дотоодод АрдМэнд, олон улсын хэмжээнд ArdMedicare (ArdMed) эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон амжилттай ажиллаж, давхарсан тоогоор 75 мянга гаруй харилцагчдад эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалтай холбоотой даатгалын үйлчилгээ үзүүлж, харилцагчдын тоо өсөн нэмэгдлээ. Коронавирусын цар тахлын улмаас иргэд эрүүл мэнддээ илүү анхаарч эхэлсэнтэй холбоотой эрүүл мэндийн даатгалын борлуулалт өсөх хандлагатай байна.

АрдМэнд дотоодын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг сонголттой, хүртээмжтэй байлгах үүднээс АрдМэнд 360 эрүүл мэндийн даатгалын багц бүтээгдэхүүнийг 2021 онд зах зээлд шинээр гаргаж даатгалын үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Компанийн хувьд салбарын бусад томоохон компаниуд болон Монголиа Ре давхар даагчтай хамтран Хүнд өвчний даатгалын Монгол улсад анх удаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн бид харилцагч, даатгуулагчдынхаа цаг завыг хэмнэх, эрүүл мэндийг хамгаалах, даатгалын үйлчилгээг илүү ойр болгох үүднээс нөхөн төлбөрийн материалыг цахимаар claims@arddaatgal.mn хаягаар хүлээн авч шийдвэрлэдэг боллоо.

Ард Даатгал компанийн зүгээс харилцагч байгууллагуудаа гэрээний хугацаанд даатгалын тохиолдолд болон эрсдэлийг удирдахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг. Энэхүү ажлын хүрээнд даатгалын үйл ажиллагааны шинжилгээг хагас жил тутамд хийж, учирсан эрсдэлүүдэд харьцуулсан судалгаа гаргаж, түүнд тохирсон зөвлөгөө, сургалт, семинаруудыг тогтмол зохион байгуулсаар байна.

Мэдээлэл технологи, цахим хэрэглээ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа өнөө үед бүх төрлийн даатгалыг харилцагчдад хурдан шуурхай хүргэх зорилгоор Ард Аппаар даатгалын үйлчилгээг үзүүлж байгаа.

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 6

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Ард Даатгал компани 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 10,151 иргэн, аж ахуйн нэгж тус компанийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд оны эхнээс 8,082 хувьцаа эзэмшигчээр буюу 5 дахин нэмэгдэж, бидэнд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл өндөр байгааг дуулгахад таатай байна.

| № | ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД | ТОО | % |
|---|---|---|---|
| 1 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 11,338,675 | 45.35 |
| 2 | Ардын Тэтгэврийн Нэрийн Данс ХХК | 1,316,554 | 5.27 |
| 3 | Мандал Капитал Маркетс ҮЦК | 1,269,868 | 5.08 |
| 4 | С. Оргил | 1,164,822 | 4.66 |
| 5 | Г. Бат-Эрдэнэ | 1,164,822 | 4.66 |
| 6 | Н. Мөнхнасан | 1,140,742 | 4.56 |
| 7 | Энержи Интернэйшнл Капитал ХХК | 820,750 | 3.28 |
| 8 | Бусад | 6,783,767 | 27.14 |
| | **НИЙТ** | **25,000,000** | **100.00** |




Мөн тайлант жилд 9.4 сая ширхэг хувьцаа эргэлтэнд орж, нийт 11.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэн Монголын Хөрөнгийн Бирж дээрх хамгийн хөрвөх чадвар сайтай хувьцаануудын нэг байсаар байна. Хувьцааны үнийн хувьд тайлант жилд 705-1,800 төгрөгийн хооронд хэлбэлзэж, жилийн эцэст 1,319 төгрөгийн үнэтэй хаагдснаар өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад 65 хувиар өсч компанийн зах зээлийн үнэлгээ 33.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 6

**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард Даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 1/3 нь буюу 3 гишүүн нь хараат гишүүд ажилладаг байна. Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилон ажиллаж байна.




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, ТУЗ-ийн гишүүнийг сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг бөгөөд 2021 оны 4 сарын 28-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хоёр жилийн хугацаатай сонгосон.
2. 2020 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулж батлуулсан байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, компанийн төсөв төлөвлөгөө, ТУЗ-ийн төсөв (цалин урамшууллын төсөв), ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.

2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 онд нэг удаа эчнээгээр, нэг удаа ээлжит бус, таван удаа ээлжит хурал зохион байгуулсан бөгөөд хурлаар ногдол ашиг олгох тухай, ХЭХ хуралдуулах тухай, компанийн төсөв, улирал, жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан болон бусад цаг үеийн асуудлуудыг хэлэлцэж шийдвэрүүд гаргаж ажилласан байна. Мөн Ард Даатгал ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороотой байна.




## НОГДОЛ АШГИЙН ТАЙЛАН

Бид хувьцаа эзэмшигчдэдээ сүүлийн арав гаруй жилийн хугацаанд ногдол ашиг олгож ирсэн бөгөөд Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 10-ны өдрийн №1/21 тоот тогтоолын дагуу компанийн 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 40 төгрөг буюу цэвэр ашгийн 48.15 хувь болох нийт 1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.

Компанийн зарласан ногдол ашгийг 2021 оны 7 сарын 2-ны өдөр “Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-тай ногдол ашиг зуучлуулан тараалгах гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлсэн.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийг эрт илрүүлэх, үнэлэх, удирдахын тулд дотоодын болон зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлүүдийг тооцоолж компанийн эрсдэлийн хороо болон төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол танилцуулах замаар хяналтын болон гүйцэтгэлийн тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Ингэснээр бидэнд эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, оновчтой удирдах, цаашлаад өөрийн давсан эрсдэлийг давхар даатгалд шилжүүлэн ажиллах боломжийг олгож байна.

Даатгалын андеррайтинг нь компанийн эрсдэлийн түвшин, ашигт ажиллагааг үнэлэх үйл ажиллагаа юм. Ингэхдээ андеррайтингийн голлох үзүүлэлтүүд болох хохирлын, зардлын болон хосолсон харьцаануудыг ашигладаг.




*LR (хохирлын харьцаа) = Нөхөн төлбөрийн цэвэр зардал / Даатгалын хураамжийн цэвэр орлого*
*ER (зардлын харьцаа) = Үйл ажиллагааны зардал / Даатгалын хураамжийн цэвэр орлого*
*CR (хосолсон харьцаа) = LR + ER*

Тайлант хугацаанд төлбөрийн чадварын зохистой харьцаа 115.9% гарсан ба даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө, төлбөрийн чадвартай байна.

| | Шалгуур | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Төлбөрийн чадварын зохистой харьцаа | >=110% | 132% | 115.9% |

Нөөц сан нь даатгалын компани нийт даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд зориулж байгуулсан мөнгөн хөрөнгө юм. 2021 оны эцсээр 3.4 тэрбум төгрөгийн нөөц сан байгуулсан нь дараагийн улирлын нөхөн төлбөрт хүрэлцээтэй байхаар байгуулсан болно. Нөөц сангийн хэмжээ жил бүр өссөн байгаа нь компанийн даатгуулагчийн өмнө хүлээх хариуцлагын чадамж улам нэмэгдэж байгааг харуулж байна.



Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 6

2021 онд Ард Даатгал ХК нь нөхөн төлбөрийн үйлчилгээгээр 5,608 даатгалын тохиолдолтой холбоотой 4.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж, даатгуулагчдын өмнө хүлээсэн даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ. Даатгалын тохиолдлын тоо өнгөрсөн оноос 16% орчим өссөн боловч бид даатгалын гэрээний эрсдэлийг бууруулсанаар нийт нөхөн төлбөр болон нэгж нэхэмжлэлийн хэмжээг тогтвортой хадгалсан байна. Мөн өнгөрсөн онд үүссэн тээвэр ложистикийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж ачаа тээврийн даатгалын нөхөн төлбөр өссөн ба сэлбэг хэрэгслийн үнийн өсөлт зэрэг нь нийт нөхөн төлбөрийн хэмжээ бага зэрэг нэмэгдсэн үндсэн шалтгаан болсон.

Жилийн үйл ажиллагааны
тайлагнал /маягт 1/-ын Хавсралт 6

**НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА**

Ард Даатгал ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө бизнесийн ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна.

- Ковид-19 цар тахлын үед, түүнчлэн хөл хорионы үед ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын ажиллагсдад зориулж нийгмийн хариуцлагын хүрээнд Ковид-19 өвчний эрсдэлээс хамгаалсан "Ковидын даатгалын" бүтээгдэхүүн шинээр зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд тус даатгалаар нийт 400 гаруй сая төгрөгийн нөхөн олговор олгон даатгуулагчдад санхүүгийн бодит тусламж үзүүлэн ажилласан байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотоос гадна орон нутгийн замд замын хөдөлгөөний ослоос сэргийлэх самбар байршуулах, сургууль, цэцэрлэгийн орчинд анхаарах тэмдэг байршуулах, жолооч нарт ослоос сэргийлэх санамж тараах, нийтийн гудамж, талбай цэвэрлэх, ариутгалын бодис, хамгаалах хэрэгсэл хандивлах зэрэг ажлуудыг шат дараатай зохион байгууллаа.
- Монгол улсын 21 аймаг, 265 сумдад оршин суугаа иргэдэд санхүүгийн бүхий л төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, мэдээлэл түгээх зорилгын хүрээнд Ард Санхүүгийн Нэгдлээс хамтран хэрэгжүүлж буй "Ардын Брокер", "Илгээлтийн Эзэд" төслүүдэд хамтран оролцлоо.
- Ард Санхүүгийн нэгдэл болон бусад охин компаниудтай хамтран Ид Шидийн орон төслийг дэмжин хамтран ажиллав.
- Ард Санхүүгийн Нэгдэл болон бусад охин компаниудтай хамтран Ковидын цар тахлын улаан бүсэд ажиллаж буй сувилагч нарт 100.000.000 төгрөгтэй тэнцэх хэмжээний АрдКойны дэмжлэг үзүүлэв.
- Дунд сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагддаг Дуулиан-2020 заалны хөлбөмбөгийн тэмцээнийг 7 дахь жилдээ дэмжин ажиллав.
- Монголын Хөлбөмбөгийн Холбоотой хамтран ажиллаж Азийн аварга шалгаруудах тэмцээнд оролцож буй тамирчдын гэнэтийн ослын даатгалын хариуцан ажилласан бөгөөд баг тамирчид тэмцээндээ амжилттай оролцож ирлээ.
- Цахим гүйлтийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монголын талаас төлөөлөн зохион байгуулж буй MGL RUNNING CHANNEL-тай хамтран ажилласан. Тус тэмцээнд Ард Даатгал компани ивээн тэтгэгчээр ажилласан бөгөөд Монголын талаас эхний 4 байрт шалгарсан тамирчдад АрдКойны урамшуулал олгосон.
- Тээврийн хэрэгсэл эзэмшигч, замын хөдөлгөөнд оролцогч нарт зориулж замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг уриалсан "Яагаад" төслийг хэрэгжүүлсэн.
- Нэг тэрбум мод тарих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ард Санхүүгийн Нэгдлийн бүх охин компаниудын ажилчид хамтран мод тарьлаа.